



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/126

Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Дулаан 6 дугаар багийн нутагт 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс хойш бог малын мялзан өвчний шинж тэмдэг илрээгүй тул 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Цаашид малчид, мал бүхий иргэдэд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэж байхыг багийн Засаг дарга нарт, Малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн "Хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай" А/119 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622301253

D:Alban bichig;Zahiramj 2023